



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/139

Мандалговь

“Аймгийн угтах, үдэх газрын тохижилт”  
ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах  
үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймгийн угтах, үдэх газрын тохижилт” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Э.Чагнаадорж (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд:

Ю.Отгондэлгэр (Иргэний төлөөлөл)

Б.Сэржмядаг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Пэрэнлэймаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргаа, Удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Э.Энхжаргал (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Чагнаадорж)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



486210585